

авсан Оросын түүхийн гоёч, сүржин бичлэгийн далайд живжээ. Европ-Азийн түүхийн энэхүү эгзэгтэй үеийн тухай Англи хэлээр тун ч хомс бичигдсэн байх нь ул үндэстэй эх сурвалж маш бага үлдсэнтэй зарим талаар холбоотой биз ээ. Галперины хувьд бол материалаа бузгай мэдэж байвч бичих авъяас ядмаг нь харамсалтай юм. Тэрээр дундад зууны үеийн Оросын түүхчдийн чадал чансааг чамалсан атлаа тэдгээр «Номтон»-ы нэг адил давтаж нуруушсан, хэт дэвэргэсэн газар зөндөө байна. Нөгөөтэйгүүр орчин үеийн эх зохиолоос олж болох байсан зарим өнгө аяс ч золгүйгээр орхигдсон тал байна. Бас нэг үгүйлэгдэж байгаа зүйл бол Монголын (байлдан дагуулалтаас) өмнөх үеийн Оросын байдал, тэр үед Хятад, Перс болон Византи, Сельжук, Отманы Түрэг, Өрнөд Европын ертөнцөд юу болж байсан тухай юм.

Эдгээр нь уг номыг илүү авъяаслаг зохиогчдын гарт байх битгий хэл мэргэжлийн бус уншигчдад ч сонирхол маш багатай болгожээ. Артур Коестлер Хазаруудыг шоовдор овогт оруулсан шиг Монголчуудыг хэн тэгж чадах билээ. Хазарууд нь угтаа Түрэг угсааны нүүдэлчид байжээ. Тэд суурьшлыг олж улмаар Еврейн шашин (Иудиазм)-нд орсон нь эцэстээ Орос болон Дорнод Европын еврейчүүдийн гарч ирэх эх үндэс болжээ. 7 ба 10-р зууны хооронд Хазарын хаант улс ихэд хүчирхэг болж Алтан Ордны улс шиг л Ижил мөрний адаг Днепр хоёрын дундах тал нутгаар төвлөрөн сууж байжээ.

Филип Боуринг Гонконг-д гардаг «ФИЭР» сэтгүүлийн  
1987 оны 12-р сарын 10-ны дугаараас **Э. Пунцаг** орчуулав.

ТҮҮХТ ХҮМҮҮСИЙН ОЙ

ХЯТАДЫН ХУВСГАЛЫН ОНОЛЧ  
(Цюй Цюбо-гийн мэндэлсний 90 жилийн ойд)

#### **Ч. Эрдэнэбаяр**

1917 онд Зөвлөлт Орос Улсад ялан мандсан аугаа их октябрийн социалист хувьсгал нь дорно дахины дарлагдан мөлжигдсэн сая сая ард түмнийг цочроосон хувьсгалт их гэрэл гэгээг түгээлээ. Октябрийн хувьсгалын нөлөөгөөр 1920-иод оноос дотоод дахь феодал газрын эзэд, хөрөнгөтөн нар хийгээд гадаадын империалистуудын давхар дарлалд талхилагдсан Хятадын ард түмний үндэсний хувьсгалт ухамсар сэргэн дээшилж, хуучин нийгмийн харгис бурангуй ёсыг халж өөрчлөх бодолтой дэвшилтэт хувьсгалт үзэлтэн нар олноор төрөх болсон юм. Тэдгээрийн тоонд Хятадын хувьсгалын онолч, марксист-ленинист сургаалыг Хятадад түгээн дэлгэрүүлэгч, Олон Улсын Коммунист Хөдөлгөөний болоод Хятадын Коммунист намын нэрт зүтгэлтэн Цюй Цюбо зүй ёсоор ордог.

Цюй Цюбо 1899 онд Цзянсу мужын Чан жоу-д төржээ.<sup>1</sup> Бага балчир наснаасаа хятадын ард түмний дарлал мөлжлөгөд нэрвэгдсэн хөөрхийлөлтэй гаслант амьдралыг нүдээр үзэн, биеэр амсаж, сэтгэл зүрхэндээ мэдэрч явсан балчир хүү Цюй Цюбо-гийн ертөнцийг үзэх үзэл төлөвшин бүрэлдэхэд ХХ зууны босгон дээр Хятад оронд өрнөх болсон хувьсгалт үйл явц, ялангуяа 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал онцгой нөлөө үзүүлсэн юм. Тэрээр Бээжингийн орос хэлний дээд сургуульд суралцаж байхдаа империализмыг эсэргүүцсэн «5-р сарын 4-ний хөдөлгөөн»-д оролцсон нь түүний улс төрийн үйл ажиллагааны эхлэл болжээ. Цюй Цюбо-гийн хэлсэнчлэн чухамхүү «5-р сарын 4-ний хөдөлгөөн» нь түүнийг ганцаардлаас гаргах, нийгэм-улс төрийн асуудлыг эрэгцүүлж бодоход хүргэжээ.<sup>2</sup> Цюй Цюбо энэ үеийнхээ байдлыг тодорхойлон: «...Анх нийгмийн амьдралд ухам сартайгаар оролцох болсон. Оюутны хөдөлгөөний явцад олж авсан нийгмийн тухай ойлголтууд маань «нийгэм» гэж юу болохыг улам гүн гүнзгий танин мэдэхэд тус дөхөм боллоо. Социализмын тухай хурц сонирхолтой маргааныг бид хийдэг байсан ч бидний үзэл бодол их төлөв ХХ зууны дөчөөд оны оросын залуучуудын дунд байсан үзэл бодолтой олон талаар ойролцоо байв. Социализмын мөн чанар, түүний олон урсгалын тухай бидний ойлголт ч бас бүрхэгдүү байсан юм...» гэж өгүүлжээ. Уг хөдөлгөөнөөс дөрвөн сарын дараа Цюй Цюбо хүсэл зорилго нэгтэй хэсэг нөхдийн хамт «Синь Шэхой» (Шинэ нийгэм) долоо хоног тутмын сэтгүүлийн анхны дугаарыг хэвлэн гаргасан<sup>4</sup> бөгөөд энэ дугаарын редакцын өгүүлэлд өөрсдийн зорилгыг илэрхийлэн нийгмийг өөрчлөн байгуулах үйл хэрэгт бүх хүчин чадлаа зориулна<sup>5</sup> хэмээн өгүүлжээ. Цюй Цюбо уг сэтгүүлд тухайн үеийн хятадын нийгмийн олон талт амьдралыг тодорхойлж, феодалын нийгмийн хоцрогдсон хэв заншил, ёс суртахууны ялзралыг шүүмжилж, шинэ үзэл бодол илэрхийлсэн анхны өгүүлүүдээ нийтлүүлэх болов. Цюй Цюбо хятадын залуучуудыг марксизмын үндсэн дээр ажиллаж, Хятадын нийгмийг өөрчлөн байгуулах хувьсгалт замаар замнахыг уриалж байв.<sup>6</sup> Тэрээр «Хятад шинэчлэгдэх цаг үе нэгэнт болсон», бүх ертөнц шинэчлэгдэж байхад зөвхөн Хятад хөгширч, хүй нэгдлийн байгуулалд эргэн орох аюул заналхийлж байна, бусад орнуудыг гүйцэн тэдний хамт ардчилал, тэгш эрхийн замаар замнан аж амьдралаа сайжруулахын төлөө ард түмэн бүгдээр хүчээ нэгтгэх хэрэгтэй гэж Хятадын ард түмнийг хувьсгалт тэмцэлд уриалж байлаа.

1920 оны 5-р сард тус сэтгүүл хаагдаж, түүний оронд сар тутмын «Жэньдао» (Хүнлэг ёс) сэтгүүлийн анхны дугаарыг 8-р сард хэвлэн гаргав.<sup>7</sup> Төдий удалгүй 1920 оны 10-р сард Цюй Цюбо Бээжингийн «Чэньбао» (Өглөөний сонин) сонины сурвалжлагчаар Москваг зорьжээ. Цюй Цюбо ийнхүү социалист ууган орны нийслэлд ажиллаж амьдрах болсон нь түүний улс төрийн үйл ажиллагааны цаашдын өрнөлт, жинхэнэ хувьсгалч, марксист болоход томоохон сургууль болсон юм. Тэрээр Москвад байх хугацаандаа В. И. Лениний сургаалыг сонсож, марксизм-ленинизмын сонгодог бүтээлүүд, шинжлэх ухааны коммунизмын онолын асуудал, октябрийн хувьсгал болоод иргэний дайны туршлагыг судалжээ. Түүний сацуу Зөвлөлт орны нийгэм-улс

төрийн амьдралыг бодитойгоор дүрсэлсэн сурвалжлага, өгүүллүүдээ Хятадын сонин хэвлэлд нийтлүүлж Хятадын ард түмний анхаарлыг хувьсгалын өлгий Зөвлөлт орны зүг хандуулж байлаа.

Цюй Цюбо 1922 онд Москва хотноо ХКН-ын эгнээнд элсэн орж, өөрийн бүхий л ухамсарт амьдралыг ХКН-ын үйл ажиллагаатай холбожээ.

1923 оны 1-р сард Цюй Цюбо Чэнь Дусю-гийн хүсэлтээр эх орондоо эргэн ирж, хувьсгалын онол практикийн жилд шууд оролцох боллоо. Түүнийг ХКН-ын ТХ-ны бүрэлдэхүүнд оруулж «Синь Циннянь» (Шинэ залуус), «Цяньфэн» (Манлайлагч) сэтгүүлүүдийн ерөнхий редактороор томилон, долоо хоног тутмын «Сяндао» (Удирдан чиглүүлэгч) сэтгүүлийн редакцийн зөвлөлд оруулжээ. Эдгээр сэтгүүлийн хуудаснаа Цюй Цюбогийн бичсэн марксист үзэл санааг дэлгэрүүлэх, Оросын хувьсгалын туршлагыг сурталчлан, Лениний зохиол бүтээлийг тайлбарласан онол улс төрийн ач холбогдолтой олон тооны өгүүллүүд нийтлэгдэх болов. Мөн түүний өгүүллүүдэд хөрөнгөтөн газрын эздийн зүсэн бүрийн бүлэглэлийн мөн чанар, хөдөөгийн тариачид, ажилчин ангийн нийгэмд эзлэх байр суурь хийгээд Хятадын нийгмийн бүтцэд марксист дүн шинжилгээ хийх гэсэн анхны оролдлогууд тусгагджээ. Цюй Цюбо тэргүүтэй Хятадын Коммунистууд өөрийн орны нийгэм улс төрийн нөхцөл байдал, ангийн хүчний харилцаанд марксист-ленинист байр сууринаас дүн шинжилгээ хийж социализмд шилжин орохын тулд Хятад нь юуны өмнө хоёр зорилтыг шийдвэрлэх ёстой. Энэ нь нэгдүгээрт, үндэсний бүрэн дүүрэн тусгаар тогтнолыг олох хоёрдугаарт, ардчилсан засгийн мэдэлд улс орныг нэгтгэх явдал юм. Чингэвэл сая үндэсний ардчилсан хувьсгалыг хийж болно гэсэн онолын зөв зүйтэй дүгнэлтэнд хүрчээ.

1920-иод оны үед милитаристуудын засгийг эсэргүүцэн тэмцэж байсан улс төрийн цорын ганц бодит хүчин болох Сунь Ятсены тэргүүлсэн гоминьданы намтай ХКН хамтран ажиллахгүйгээр үндэсний хувьсгалыг амжилтанд хүргэж эс чадна гэсэн байр суурийг Цюй Цюбо баримталж байлаа. Тэрээр тухайн үеийн улс төрийн нөхцөл байдлыг зөвөөр үнэлж, ХКН-аас баримтлах бодлогыг ийнхүү марксист ленинист онолын үүднээс боловсруулалцахад биеэр оролцож байв.

Энэ үед Цюй Цюбо мөн хувьсгалт боловсон хүчнийг хүмүүжүүлэн бэлтгэхэд ихээхэн анхаарч Шанхайн их сургуулийн оюутнуудад социологи, соёлын түүх, социализмын асуудлаар лекц уншиж байжээ.

Хувьсгалын жилүүдэд тэрээр тариачдын газар тариалангийн асуудалд анхааран «Газрыг хэн боловсруулна-тэр эзэмшинэ», «Газрыг тариачдад» зэрэг уриалгыг дэвшүүлэн, Хятадад тариачдын дайныг өрнүүлэх нь Хятадын хувьсгалд онц тааламжтай болохыг дурьдаад ажилчин ангиар удирдуулсан тариачдын бат нэгдэлгүйгээр хувьсгалд амжилт эс олж чадахыг тэмдэглэсэн байна.

1927 оны хавар Чан Кайши хувьсгалын эсэргүү эргэлт гаргаж гоминьдан нам, ХКН-ын хамтын ажиллагаа тасалдаж нэгдмэл фронт устахад хүрэв. Мөн оны 8-р сард ХКН-ын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Чэнь Дусю намын чиг шугаманд «баруун оппортунист» бодлого баримтлах болсоны улмаас зайлуулагдан, Цюй Цюбо уг албан тушаалд ажиллах боллоо. Ер нь тэр үеийн ХКН-ын удирдагчдын дотроос марксист-ленинист онолын мэдлэгээрээ Цюй Цюбо ялгарч

байсан бөгөөд тэрээр ХКН-ыг удирдах болсон эхний жилүүдэд намын дотор «баруун оппортунист» Чэнь Юусю болон түүний талынхантай улс төрийн тэмцэл явуулж, хот орон, хөдөө тосгодод Зэвсэгт бослогыг зохион байгуулах замаар хувьсгалыг өргөтгөн гүнзгийрүүлэх ажилд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Цюй Цюбогийн удирдаж байсан ХКН, гоминьданы намтай хамтран ажиллахаа больсоноор улс төрийн талаар бүрэн бие даасан хүчин болж, Хятадын хөдөөгийн районуудад Зөвлөл, Улаан армийг байгуулан гоминьданы эсрэг урт удаан хугацааны Зэвсэгт тэмцлийг явуулах болжээ.

1928 онд Москва хотноо хуралдсан ХКН-ын VI их хурал дээр Цюй Цюбо шинэ үе шатан дахь намын зорилтууд, хувьсгалын үр дүнгийн тухай илтгэл тавьж Хятадын хувьсгал нь хөрөнгөтний ардчилсан шинж чанартай болохыг тодорхойлжээ. Харин үндэсний хөрөнгөтөн ангийн хувьсгалын эсэргүү мөн чанар, хувьсгалт ангийн бүтэц зэрэг асуудлаар санал зөрөөтэй байсан боловч Хятадын хувьсгалын тэрхүү хүнд бэрхшээлтэй цаг үед онол, практикийн эрэл хайгуулыг шаргуу хийж хувьсгалын үйл хэргийг урагшлуулахад Цюй Цюбогийн оруулсан хувь нэмэр чухал гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

1920-иод оны сүүлчээр Цюй Цюбо Москва хотноо Коминтерны Төв Байгууллагад удирдах ажил хийж, империализмыг эсэргүүцсэн олон улсын нэгдмэл фронт байгуулах үйлст мэдлэг, чадвараа зориулж байв. Цюй Цюбо 1930-аад оны эхээр марксизм-ленинизмын сонгодог бүтээлийг хятад хэлнээ хөрвүүлж, утга зохиолын онолын асуудлаар оролдон, Орос-Зөвлөлтийн зохиолчдын зохиол бүтээлээс орчуулж хятадын уншигчдад толилуулж байв. Цюй Цюбо мөн Лу Синь тэй хамтарч утга зохиол дахь элдэв харш үзэлтнүүдийн эсрэг тэмцэл явуулж байсан ба түүний хувьд утга зохиол нь нийгмийг өөрчлөх хэрэгсэл, улс төрийн тэмцлийн чухал хэсэг юм.

1934 оны 1-р сард Цюй Цюбо Шанхайгаас Хятадын Зөвлөлт районд шилжин ирж Төв засгийн газрын боловсрол гэгээрэл хариуцсан ардын комиссараар ажиллах болов. Цюй Цюбод хувьсгалт дайны хүнд бэрх нөхцөлд сургууль, соёлын байгууллага, театрын бүлгүүдийг зохион байгуулан хөгжүүлэх хүнд хариуцлагатай үүрэг ноогдсон бөгөөд тэрээр биеийн эрүүл мэнд тааруу байсан хэдий ч шинэ Хятадын соёл урлагийг хөгжүүлэх үйл хэрэгт бие харамгүй зүтгэсэн юм.

1934 оны намар Хятадын Улаан Арми улс орны умард зүгт их аян хийх үед өвчин зовлонд нэрвэгдсэн Цюй Цюбо уулын нэгэн бяцхан тосгонд хоцорчээ. 1935 оны 2-р сард Цюй Цюбог гоминьданчууд баривчлан авч улмаар цаазлав. «Соёлын хувьсгал»-ын хүнд бэрх жилүүдэд түүний шарилыг улаан хамгаалагчид доромжлон бусниулж хувьсгалын эсэргүү, урвагч мэтээр тунхаглан зарлажээ. Гэвч түүхийн үнэн ялдаг жам ёсоор, өнөө үед БНХАУ-д Цюй Цюбогийн алдар гавьяаг нэхэн сэргээж, «...Намыг удирдах хүнд бэрх ажлынхаа зэрэгцээгээр 800 гаруй өгүүлэл, товхимол бичиж, нийт 5 сая дүрс үсэг бүхий орчуулга хийсэн...» түүний улс төр, утга зохиолын өргөн цар хүрээтэй үйл ажиллагааг нь анхааралтай судалж байна. Хятадын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө мятаршгүй тэмцэгч энэ хүний хятадын хувьсгалын онолын асуудлыг боловсруулах, марксист-ленинист үзэл санааг Хятад оронд дэлгэрүүлэх хийгээд Хятадын ши-